

УЛСЫН ШАЛГАЛТ-2025

МАТЕМАТИК

V АНГИ



САНАМЖ, ЗӨВЛӨМЖ

- Шалгалт 60 минут үргэлжилэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан бүх даалгаврыг гүйцэтгээрэй.
- Шалгалтын материал нь сонгох хариулт бүхий тест, задгай хэлбэрийн даалгавруудаас бүрдэнэ.
- Сонгох хариулттай даалгаврууд тус бүр 1 оноотой байна.

А ХУВИЛБАР

СУМ:.....

СУРГУУЛЬ:

АНГИ: БҮЛЭГ:

ОВОГ:

НЭР:

5 ДУГААР АНГИЙН “МАТЕМАТИК” ХИЧЭЭЛИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ А ХУВИЛБАР

Хугацаа 60 минут

Нийт оноо –25

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

- Саяын ангийн 52 нэгж, мянгын ангийн 405 нэгж, нэгжийн ангийн 23 нэгжээс бүтсэн тоог цифрээр бичээрэй.
 A. 5240523 B. 23405052 C. 52405023 D. 520405023
- Аль бутархай $\frac{6}{10}$ -тай тэнцүү вэ?
 A. $\frac{3}{10}$ B. $\frac{6}{5}$ C. $\frac{6}{20}$ D. $\frac{3}{5}$
- $\frac{45}{100}$ бутархайг процентоор илэрхийлээрэй.
 A. 45% B. 0.45% C. 4.5% D. 4.05%
- $3 \div 7 = \square \div 35$ Пропорцын мэдэгдэхгүй байгаа гишүүнийг олоорой.
 A. 21 B. 15 C. 105 D. 245
- Талбайг хэмжих нэгжийг зөв шилжүүлээрэй. **1 га = ?**
 A. 10м.кв B. 100м.кв C. 1000м.кв D. 10000м.кв
- Дүрсийн мэдэгдэхгүй байгаа өнцгийг олоорой.
 A. 180° B. 160° C. 360° D. 85°
- Уутан дотор 8 бөмбөг байв. Түүний 5 нь хар, 3 нь цагаан бөмбөг байжээ. Харахгүйгээр уут руу гараа хийж нэг бөмбөг авахад хар бөмбөг байх боломж хэд вэ?
 A. $\frac{5}{8}$ B. $\frac{3}{5}$ C. $\frac{5}{3}$ D. $\frac{3}{8}$



ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР


1. Хоёр тооны нийлбэр 35978, ялгавар нь 3604 бол тоо түс бүрийг олоорой.

[illegible]


2. Хасагдагчийг 1.25-аар ихэсгэхэд ялгаврын утга хэрхэн өөрчлөгдөх вэ?. Хариугаа тайлбарлан бичээрэй.

[illegible]


3. Дэлгүүрт 9ц чихэр байсны 0.3-г эхний өдөр, үлдсэн чихрийн $\frac{2}{7}$ -г хоёр дахь өдөр, үлдсэн чихрийг 3 дахь өдөр худалдсан бол 3 дахь өдөр хэдэн кг чихэр худалдсан бэ?





4. Дэвтрийн үнэ 160 төгрөгөөр нэмэгдсэн нь анхны үнийн 20% байв. Дэвтрийн анхны үнэ хэд байсан бэ?



5. Улаанбаатар хотоос Арвайхээр хот хүртэл 420км. Энэ зайг газрын зураг дээр 84см хэмжээтэй зурав. Газрын зургийн масштабыг олоорой.




6. А. Зургаар өгсөн тэгш өнцөгт параллелолипедийн дэлгээсийг зураарай. (1 см – ийг 1 нэгж гэж үзнэ)



Б. Гадаргуугийн талбайг олоорой.


В. Эзлэхүүнийг олоорой.




7. Тэгш өнцөгт координатын хавтгай өгөв.

а. $A(2, 6)$, $B(5, 6)$, $C(5, 8)$ цэгүүдийг тэмдэглэж, тэдгээрийг холбон гурвалжин үүсгээрэй.

б. ABC гурвалжинг өгсөн b шулууны хувьд тэгш хэмтэй хувиргаарай.



8. 5 цамц, 3 өмд, 2 гутлыг хэдэн янзаар хослуулан өмсөж болох вэ? Модны схем ашиглан үзүүлээрэй.



_____оОо_____

УЛСЫН ШАЛГАЛТ-2025

МАТЕМАТИК V АНГИ



САНАМЖ, ЗӨВЛӨМЖ

- Шалгалт 60 минут үргэлжилэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан бүх даалгаврыг гүйцэтгээрэй.
- Шалгалтын материал нь сонгох хариулт бүхий тест, задгай хэлбэрийн даалгавруудаас бүрдэнэ.
- Сонгох хариулттай даалгаврууд тус бүр 1 оноотой байна.

Б ХУВИЛБАР

СУМ:.....

СУРГУУЛЬ:

АНГИ: БҮЛЭГ:

ОВОГ:

НЭР:


**5 ДУГААР АНГИЙН “МАТЕМАТИК” ХИЧЭЭЛИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ
Б ХУВИЛБАР**

Хугацаа 60 минут

Нийт оноо –25

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

- Саяын ангийн 524 нэгж, мянгын ангийн 24 нэгж, нэгжийн ангийн 105 нэгжээс бүтсэн тоог цифрээр бичээрэй.
 A. 52424105 B. 524240105 C. 524240150 D. 524024105
- Аль бутархай $\frac{12}{16}$ -тай тэнцүү вэ?
 A. $\frac{4}{16}$ B. $\frac{12}{8}$ C. $\frac{3}{4}$ D. $\frac{16}{12}$
- $\frac{27}{100}$ бутархайг процентоор илэрхийлээрэй.
 A. 2.7% B. 27% C. 270% D. 2.07%
- $\square \div 18 = 27 \div 9$ Пропорцын мэдэгдэхгүй байгаа гишүүнийг олоорой.
 A. 2 B. 3 C. 54 D. 162
- Талбайг хэмжих нэгжийг зөв шилжүүлээрэй. **1 ар = ?**
 A. 10м.кв B. 100м.кв C. 1000м.кв D. 10000м.кв
- Дүрсийн мэдэгдэхгүй байгаа өнцгийг олоорой.
 A. 180^0 B. 63^0 C. 360^0 D. 97^0
- Уутанд 7 цагаан, 8 улаан, 9 хар бөмбөг байжээ. Харахгүйгээр уут руу гараа хийж нэг бөмбөг авахад хар бөмбөг байх боломж хэд вэ?
 A. $\frac{1}{7}$ B. $\frac{7}{16}$ C. $\frac{7}{15}$ D. $\frac{9}{24}$




ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР

1. Хоёр тооны нийлбэр 35058, ялгавар нь 3604 бол тоо тус бүрийг олоорой.


[illegible]

2. Хасагчийг 1.25-аар ихэсгэхэд ялгаврын утга хэрхэн өөрчлөгдөх вэ? Хариугаа тайлбарлан бичээрэй.


3. Агуулахад байсан гурилын 0.4-г талхны нэг үйлдвэрт, үлдсэн гурилын $\frac{2}{5}$ -г хоёр дахь үйлдвэрт өгөхөд агуулахад 72тн гурил үлдэв. Агуулахад анх хэдэн тонн гурил байсан бэ?





4. Дэвтрийн үнэ 160 төгрөгөөр нэмэгдсэн нь анхны үнэ 800 төгрөгийн хэдэн процент болох вэ?



5. 1:2 000 000 масштабтай газрын зураг дээр Улаанбаатараас Өндөрхаан хот хүртэлх зайг 16.5см хэмжээтэй зурав. Улаанбаатараас Өндөрхаан хот хүртэл хэдэн километр зайтай вэ?




6. А. Зургаар өгсөн тэгш өнцөгт параллелипедийн дэлгээсийг зураарай. (1 см – ийг 1 нэгж гэж үзнэ)



Б. Гадаргуугийн талбайг олоорой.


В. Эзлэхүүнийг олоорой.




7. Тэгш өнцөгт координатын хавтгай өгөв.

а. $A(3, 2)$, $B(1, 4)$, $C(4, 5)$ цэгүүдийг тэмдэглэж, тэдгээрийг холбон гурвалжин үүсгээрэй.

б. ABC гурвалжинг өгсөн a шулууны хувьд тэгш хэмтэй хувиргаарай.



8. 4 цамц, 3 өмд, 2 гутлыг хэдэн янзаар хослуулан өмсөж болох вэ? Модны схем ашиглан үзүүлээрэй.



_____оОо_____